



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 1154

Улиастай

Эрүүл мэндийн байгууллагуудын
тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, шинжээч
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.18 дахь заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2019 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг шинээр сунгах, олгох, шинжээч ажиллуулах байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.


2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, сунгасан байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс /Л.Лхамсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ч.Дэмчигсүрэн/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /А.Шаравжамц/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /Н.Бямбадорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТСАЙХАН



Zahiramj2019

01190530

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах байгууллагын нэрсийн жагсаалт

д/д	Байгууллагын нэр	Зөвшөөрөл дуусах хугацаа	Сунгасан хугацаа
1	Улиастай Тунгийн увидис хувийн эмийн сан	2019.03.01	5 жил
2	Улиастай Үе залгамжлагч элит сувилал	2019.03.26	5 жил
3	Цагаан хайрхан Эмийн эргэлтийн сан	2019.03.10	5 жил
4	Дөрвөлжин Эмийн эргэлтийн сан	2019.03.19	5 жил
5	Сонгино Эмийн эргэлтийн сан	2019.02.16	5 жил
6	Сантмаргац Эрүүл мэндийн төв	2019.03.24	5 жил

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон
байгууллагын нэрсийн жагсаалт

д/д	Байгууллагын нэр	Дуусах хугацаа	Олгосон хугацаа
1	Төгс жаргалан үүдэн эмнэлэг	2022.04.02	3 жил
2	Монос ХХК –ны салбар эмийн сан	2022.04.02	3 жил
3	"Өвөгдий" хувийн эмийн сан	2022.04.02	3 жил
4	Баясгаланг хурахуй шүдний эмнэлэг	2022.04.02	3 жил

3. Шинжээч ажиллуулах байгууллагын нэрсийн жагсаалт

д/д	Харъяалал	Төслийн нэр
1.	Их уул сум	Элбэг эмийн сангийн төсөл
2	Улиастай сум	Увидисын далай эмийн сангийн төсөл

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН КОМИСС